



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/62

Булган сум

Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн зөвлөгөөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг, 53 дугаар зүйлийн 53.1.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан “Улсын хил хамгаалалтад иргэнийг оролцуулах журам”-ын 3.7 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн зөвлөгөөн зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга, бөгөөд хил хамгаалах туслах хүчний орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

2.Зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах 3,068,800 (гурван сая жаран найман мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Баясгалан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

